



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.4 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Соёлын элчийн тухай журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Монгол Улсын Соёлын элчийн журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад сурталчилгаа, мэдээллийн газрын захирал (Х.Мандахцэцэг), Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан Гадаад хэргийн сайдын 2006 оны 29 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ПҮРЭВСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ЭЛЧИЙН ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Соёлын элчийг (цаашид “Соёлын элч” гэх) томилох, түүний үйл ажиллагаа, эрх үүргийг тодорхойлох, хамтран ажиллах, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Соёлын элч нь дипломат эрх ямба, дархан эрх эдлэхгүй.
- 1.3. Соёлын элчийн үйл ажиллагаа нь ил тод, түүх болон шинжлэх ухааны үндэслэлтэй, алагчлахгүй, хуульд нийцсэн байна.

Хоёр.

Соёлын элчийг томилох

- 2.1 Гадаад хэргийн сайд Соёлын элчийг томилж, чөлөөлнө.
- 2.2 Монгол Улсын иргэнийг Соёлын элчээр томилоход дараах шаардлага тавигдана.
 - 2.2.1 Нобел, Оскарын шагналтан, эсхүл үүнтэй дүйцэх хэмжээний олон улсын шагналтан байх,
 - 2.2.2 Олимпийн аварга тамирчин байх,
 - 2.2.3 Сумо бөхийн макүүчи зиндаанд хамгийн олон түрүүлсэн тамирчин байх,
 - 2.2.4 Олимп, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний медальтай тамирчин байх,
 - 2.2.5 Дэлхийн эхний тавьд эрэмбэлэгдсэн театрт тоглож буй хөгжимчин, бүжигчин, жүжигчин байх,
 - 2.2.6 Гадаад улсад 10 жилээс дээш хугацаанд оршин сууж буй, соёл, урлаг, спорт, хүмүүнлэг, түүхийн чиглэлээр ажилласан туршлагатай, тухайн улсдаа болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн иргэн байх.
- 2.3 Монгол Улсын иргэн Соёлын элчээр томилогдон ажиллах хүсэлтээ Гадаад хэргийн сайдад ирүүлнэ.
- 2.4 Гадаадын иргэнийг Соёлын элчээр томилоход дараах шаардлага тавигдана.
 - 2.4.1 Соёл, урлаг, спорт, түүх, эрдэм шинжилгээ, хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, суугаа улсдаа болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй иргэн байна.
- 2.5 Гадаадын иргэн Соёлын элчээр ажиллах хүсэлтээ тухайн улсад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар (цаашид “ДТГ” гэх)-т ирүүлнэ. Тухайн улсад Монгол Улсын ДТГ байдаггүй бол хүсэлтээ Гадаад хэргийн сайдад ирүүлнэ.

- 2.6 Соёлын элчийн тоог хязгаарлахгүй.
- 2.7 Соёлын элчээр ажиллах хүсэлт гаргахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 2.7.1 Гадаад хэргийн сайдад хандаж бичсэн албан ёсны хүсэлт,
- 2.7.2 Нэр дэвшигчийн намтар, одоо эрхэлж буй ажил, үйл ажиллагааны тухай танилцуулга,
- 2.7.3 Соёлын элчээр ажиллах хугацаандаа хийж гүйцэтгэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй хөтөлбөр,
- 2.7.4 Нэр дэвшигчийн талаар соёл, урлаг, түүх, спорт, хүмүүнлэгийн байгууллага, нэр хүндтэй хүнээс гаргасан гурваас доошгүй тодорхойлолт,
- 2.7.5 Нэр дэвшигчийн талаар цагдаагийн байгууллагын тодорхойлолт.
- 2.8 Гадаад хэргийн яамны Гадаад сурталчилгаа, мэдээллийн газар (цаашид “ГСМГ” гэх) Соёлын элчээр ажиллах хүсэлтийг хянаж, холбогдох ДТГ-ын саналыг авч, Гадаад хэргийн сайдад танилцуулан, томилох эсэх шийдвэрийг гаргуулна.
- 2.9 ГСМГ, ДТГ энэхүү журмын 2.2, 2.4 дэх заалтын шалгуур хангасан иргэнийг Соёлын элчээр томилон ажиллуулах санал гаргах эрхтэй.
- 2.10 Соёлын элчийн гэрчилгээг энэхүү журмын хавсралтад заасан загвараар үйлдэж, Гадаад хэргийн сайд шийтгэн олгоно.
- 2.10.1 Соёлын элчид олгосон гэрчилгээний цахим хувийг ГСМГ, Гадаад хэргийн төв архивт хадгална.
- 2.11 Соёлын элчийн томилолтын хугацаа таван жил байна.
- 2.12 Энэхүү журмын 4.1.3-д заасан дүгнэлтийг үндэслэн Соёлын элчийн томилолтын хугацааг Гадаад хэргийн сайдын шийдвэрээр таван жилээр сунгана.
- 2.12.1 Томилолтын хугацааг сунгахдаа Соёлын элчийн гэрчилгээг шинэчлэн олгож, хуучин гэрчилгээнд “Дурсгал болгов” тэмдэг дарж, Соёлын элчид хадгалуулна.
- 2.13 Соёлын элчийг томилоход зөвшөөрөл авахаар тухайн улсын хуульд заасан бол тус зөвшөөрлийг дипломат шугамаар тавьж авна. Бусад тохиолдолд зөвшөөрөл хүсэхгүй.
- 2.14 Соёлын элчийн томилолтыг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно. Үүнд:
- 2.14.1 Томилолтын хугацаа дуусгавар болсон,
- 2.14.2 Үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүйгээ бичгээр илэрхийлсэн, эсхүл эрх зүйн чадамжгүй болсон,
- 2.14.3 Энэхүү журам болон хууль зөрчсөн, эсхүл холбогдох улсын эрх бүхий байгууллагаас түүний үйл ажиллагааг зогсоох хүсэлт, шаардлага тавьсан,
- 2.14.4 Энэхүү журмын 3.2.1-3.2.9-д заасан болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,
- 2.15 Соёлын элчийн томилолт дуусгавар болсноор түүнд олгосон гэрчилгээ хүчингүй болсонд тооцогдоно.
- 2.16 Соёлын элчийг томилсон, эсхүл чөлөөлсөн тухайгаа ДТГ-аар дамжуулан холбогдох улсын эрх бүхий байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

Гуравдугаар бүлэг
Соёлын элчийн эрх, үүрэг

- 3.1 Соёлын элч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.1.1 “Монгол Улсын Соёлын элч” гэсэн захидлын хэвлэмэл хуудас, нэрийн хуудас ашиглана.
 - 3.1.2 Монгол Улсын Гадаад хэргийн яам, ДТГ, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай харилцана.
 - 3.1.3 Соёл, урлаг, спорт, түүх, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулна.
 - 3.1.4 Монголын соёл, урлагийн чиглэлээр арилжааны арга хэмжээ зохиохдоо тухайн улсын холбогдох зөвшөөрлийг авч, татвар төлнө.
 - 3.1.5 Оршин суугаа орны нутаг дэвсгэрийн гадна энэхүү журамд заасан үйл ажиллагааг бусад Соёлын элчийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө учруулахгүй байдлаар явуулна.
 - 3.1.6 Монгол Улсын соёлын бусад элч нартай хамтран ажиллана.
- 3.2 Соёлын элч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 3.2.1 Монгол Улсын нэр хүндийг эрхэмлэн дээдэлнэ.
 - 3.2.2 Монгол Улсыг сурталчилна.
 - 3.2.3 Монголын түүхийн үнэт өвийн талаар авагдсан мэдээллийг ГСМГ, ДТГ-т нэн даруй мэдэгдэнэ.
 - 3.2.4 Соёлын элчийн үүрэгт ажлыг хашихдаа Монгол Улсаас аливаа цалин хөлс авахгүй.
 - 3.2.5 Соёл, урлаг, спорт, эрдэм шинжилгээ, хүмүүнлэгийн арга хэмжээ, хамтын ажиллагааны боломжийн талаар ГСМГ, ДТГ-т мэдээлж байна.
 - 3.2.6 Монгол Улсын болон тухайн улсын холбогдох байгууллагуудын хооронд харилцаа тогтооход дэмжлэг үзүүлнэ.
 - 3.2.7 ГСМГ, ДТГ-аас өгсөн гадаад сурталчилгааны албан ёсны мэдээллийн агуулгыг үйл ажиллагаандаа баримтална.
 - 3.2.8 Жилийн ажлын тайлангаа 12 дугаар сарын 5-ны дотор багтаан холбогдох ДТГ, ГСМГ-т бичгээр ирүүлнэ.
 - 3.2.9 Төсвийн болон бусад санхүүжилтээр арга хэмжээ зохиосон бол санхүүгийн тайланг тухай бүр холбогдох ДТГ, санхүүжилт олгосон байгууллага, ГСМГ-т ирүүлнэ.
 - 3.2.10 Соёлын элч томилолтын хугацаандаа хийж гүйцэтгэх ажлын талаар ГСМГ-тай гэрээ байгуулж ажиллана.

Дөрөвдүгээр бүлэг
Соёлын элчийг дэмжих, үйл ажиллагааг нь дүгнэх

- 4.1 ГСМГ дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 4.1.1 Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагаас Соёлын элчтэй харилцаа, хамтын ажиллагаа тогтоох, харилцан мэдээлэл солилцох ажлыг нэгдсэн зохицуулалтаар хангана.

- 4.1.2 Соёлын элчийн үйл ажиллагааг шууд болон холбогдох ДТГ-аар дамжуулан удирдаж ажиллана.
- 4.1.3 Соёлын элчийн жилийн ажлын тайлан, гэрээний хэрэгжилт, ДТГ-ын дүгнэлтийг үндэслэн тухайн Соёлын элч үүрэгт ажлаа хэрэгжүүлсэн байдлын талаар жил бүр дүгнэлт гаргаж Гадаад хэргийн сайдад илтгэнэ.
- 4.1.4 Соёлын элчийн цахим мэдээллийн санг хөтөлнө.
- 4.1.5 Соёлын элчийн нэр, албаны хаягийг ГХЯ-ны вэб хуудсанд нийтэлнэ.
- 4.2 ДТГ нь дараах үүрэгтэй байна. Үүнд:
 - 4.2.1 Соёлын элчийг дэмжиж ажиллана.
 - 4.2.2 Үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө Соёлын элчтэй хамтран ажиллах чиглэлийг тусгана.
 - 4.2.3 Соёлын элчийн үйл ажиллагаа энэхүү журам, хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.
 - 4.2.4 Соёлын элчийн жилийн ажлын тайлан, гэрээний хэрэгжилтийн талаар ДТГ дүгнэлт гаргаж 12 дугаар сарын 10-ны дотор ГСМГ-т ирүүлнэ.
- 4.3 Энэхүү журмын 2.2.2, 2.2.3-д заасан Соёлын элчид дипломат паспорт олгоно.
- 4.4 Энэ зүйлд заасан үүргийг хэрэгжүүлээгүй дипломат ажилтан ГХЯ, ДТГ-ын хөдөлмөрийн дотоод журам, Дипломат ажилтны сахилгын тусгай дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 4.5 Соёлын элчийг ГХЯ, ДТГ-т ажлын цагаар саадгүй нэвтрүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ЭЛЧИЙН ГЭРЧИЛГЭЭ

- 1 Монгол Улсын Соёлын элчийн гэрчилгээг англи, монгол бичгээр бичиж, Гадаад хэргийн сайд гарын үсэг зурж, тамгална. Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын айлчлалын үеэр гардуулах гэрчилгээнд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гарын үсэг зурж, тамгална.
- 2 Соёлын элчийн гэрчилгээнд түүний нэр, иргэншил, паспортын дугаар, оршин суугаа улс, хот, томилолтын хугацааг бичнэ.
- 3 Соёлын элчийн гэрчилгээг сүлдтэй, нууцлал бүхий цаасан дээр хэвлэнэ.
- 4 Соёлын элчийн гэрчилгээ давтагдашгүй дугаартай байна. Дугаарын эхний 2 орон оныг, дараагийн 3 үсэг тухайн оршин суугаа орны товчилсон нэрийг (НҮБ-ын Статистикийн хэлтсийн баталснаар), дараагийн 3 оронтой тоо гэрчилгээний дугаарыг илтгэнэ.